

Нууцлагдсан аюулууд!

2019 оны 8-р сар

Зарим аюул нь бусад аюултай харьцуулахад илт мэдэгдэхүйц байдаг. Тухайлбал бид бүгд хурц иртэй хутгыг хараад зүсэх аюулыг нь мэддэг учраас болгоомжтой харьцдаг.

Аюултай материал нөөцлөх савны гадна зохих хаягжилт байвал бид мөн л дээрхтэй адил ханддаг. Гэвч нөөцлөх сав эсвэл шугам хоолой нь хоосон, дүүрэн, даралттай эсэхийг тогтоох хэцүү. Ялангуяа тухайн үйлдвэрлэлийн процесст ашиглагддаг бүх материал, энергитэй холбоотой аюулуудын талаар бүрэн ойлголттой байх бүүр ч хэцүү.

Нэгэн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралтыг салгах үед ямар ч тэмдэглэгээ, хаягжилтгүй шугам хоолойд хүхрийн хүчил илэрсэн бөгөөд ажилтанд гэмтэл учруулсан байна.



Тэгэхээр бид юу хийх шаардлагатай вэ? Хангалттай мэдээлэлтэй болох хүртэл бүх төрлийн аюулыг хамгийн ноцтой түвшинд байгаа мэт хандах хэрэгтэй.

Та мэдэх үү?

Энэ яагаад чухал вэ? Та зөвхөн нүдээр харсан, тодорхойлсон аюулыг л хянах боломжтой. Химийн эсвэл нефть-химийн үйлдвэрүүдэд үйл ажиллагааны процессыг шууд харуулах олон хөдөлгөөнт эд анги байдаггүй. Тэгэхээр аюулыг таньж тодорхойлох, ойлгох шаардлагатай ба тэдгээрийг хянах систем байх хэрэгтэй гэсэн үг.

Ялангуяа даралтат сав, шугам хоолойг нээхийн өмнө холбогдох аюулуудын талаар мэддэг байх нь чухал. Боловсруулах тоног төхөөрөмж дотор ямар материал байгаа эсвэл байсан талаар, мөн температур ба даралтын хэмжээг сайн мэдэхгүйгээр ажилд бэлтгэх хэцүү бөгөөд энэ нь аюул учрах боломжтой.

Та юу хийж чадах вэ?

- Үйлдвэрлэлийн процесс болон тоног төхөөрөмж тус бүрд агуулагдах материалын талаар мэддэг бай. Урвал явагддаг системийн хувьд цаг хугацааны явцад өөрчлөлт орж болзошгүй.
- Шугам хоолой, тоног төхөөрөмжийн хаягжилт бүрэн зөв, нүдэнд харагдахаар, уншигдахаар байгаа эсэхийг нягтлан шалга.
- Өөр өөр материалыг боловсруулахтай холбоотойгоор тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа өөрчлөгдөх эсвэл төхөөрөмжийг солих тохиолдолд Өөрчлөлтийн Менежментийн (МОС) дагуу зохих үзлэг шалгалтыг хийж, тоног төхөөрөмжийн хаягжилтыг шинэчлэх шаардлагатай эсэхийг тогтоо.
- Шугамыг задлах, даралтат савыг нээх, түгжиж пайзлах (LOTO) журмуудыг мөрд.
- Системийг эдгээр үйл ажиллагаанд бэлтгэх үед шаардлагатай зөвшөөрлүүдийг бүрэн бүрдүүлэх ёстойг хатуу анхаар. Хэрэв ямар нэгэн тодорхой бус, шийдэгдээгүй асуудал байвал процессыг үргэлжлүүлэхээс өмнө зогсолт хийж, нөхцөл байдлыг шалгуул. Ажлын зөвшөөрөлтэй холбоотой алдааны улмаас олон осол тохиолдож байсан (2018 оны 6-р сарын *Beacon*-ыг хар).

Холбогдох материал: 1. Morey, A. "Corrosion Under Insulation Revisited: Aren't We About to Finish that Project?" *Process Safety Progress* 37 (4), pp. 502-505, December 2018.
2. US Chemical Safety Board report, <https://www.csb.gov/chevron-refinery-fire/>

Аюулыг таньж тодорхойлох – нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны эхний алхам юм!

© AIChE 2017. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. Арилжаа, худалдааны бус харин сургалтын зорилгоор хуулбарлаж ашиглахыг дэмжинэ. Харин арилжаа, худалдааны зорилгоор AIChE –с бичгээр илэрхийлсэн зөвшөөрөл аваагүй тохиолдолд хуулбарлаж ашиглахыг хатуу хориглоно. Бидэнтэй ccps_beacon@aiche.org эсвэл 646-495-1371 хаягаар холбогдоно уу.